




MONGOLIAN CASHMERE



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

# ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

-2018-



## АГУУЛГА

- 02-05** КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА  
Бүтэц зохион байгуулалт  
Бүтэц зохион байгуулалтад гарсан гол өөрчлөлтүүд
- 06-11** БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
Онцлох үйл явдлууд  
Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, хөгжүүлэлт  
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
Шинэ коллекциуд
- 12-17** САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд  
Санхүүгийн тайлан  
Их хэмжээний хэлцэл  
Сонирхлын зөрчилтэй хэлцэл  
Санхүүжилтийн мэдээлэл  
Компанийн удирдлагын зардал
- 18-19** ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА  
Хувьцааны арилжаа  
Ногдол ашиг
- 20-31** КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ  
Засаглалын тогтолцоо  
Хувьцаа эзэмшигчид  
Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Төлөөлөн удирдах зөвлөл  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн  
Эрх бүхий албан тушаалтнууд  
Тогтвортой хөгжил  
Нийгмийн хариуцлагын тайлан



## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь Хувьцаат Компани
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолууранд цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Компанийн албан ёсны хаяг	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9 сарын 5-ны өдөр
Ажилтнуудын тоо	2,005
Хүчин чадал	900 тонн түүхий ноолуур боловсруулах 500 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх 1,000,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 150,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх
Дэлгүүрийн тоо	Дотоод Улаанбаатар хот 7 Дархан хот 1  Гадаад Салбар дэлгүүр 5 Франчайз дэлгүүр 53

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна.

## ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Компанийнхаа төлөө зүрх сэтгэл, бүхий л авьяас чадвараа дайчлан ажиллаж буй чадварлаг мэргэжилтэн, ажилтнууд
- Бидэнтэй үргэлж хамт байдаг нийт хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
- Дэлхийд хосгүй Монгол ноолуур
- Дэлхийн дэвшилтэт технологийн үйлдвэр

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

## УРИА ҮГ

Дэлхийд танигдсан Монгол брэнд





## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

### 1. Захиргаа, хүний нөөцийн газартай холбоотой:

- Хүний нөөцийн хэлтсийг Хөдөлмөрийн харилцааны алба, Сургалт хөгжлийн алба гэж 2 салгасан.
- Хүний нөөцийн хэлтсийн дарга, Сургалт хөгжлийн албаны дарга, Хөдөлмөрийн харилцааны албаны дарга, Захирлын ахлах туслах гэсэн ажлын байруудыг шинээр бий болгосон.

### 2. Гадаад худалдааны газартай холбоотой:

- Гадаад худалдааны газрыг Европ, Ази гэсэн 2 газарт хуваасан.
- Гадаад худалдаа хариуцсан дэд захирал /европ/, Төлөвлөлтийн албаны дарга, Маркетингийн албаны дарга гэсэн ажлын байруудыг шинээр бий болгосон.

### 3. Санхүү бүртгэл, удирдлагын газартай холбоотой:

- Санхүү төлөвлөлтийн хэлтсийг шинээр байгуулсан.
- Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга, Бизнес шинжилгээний албаны дарга, Санхүү бүртгэлийн хэлтэст хяналтын тоологч гэсэн ажлын байруудыг шинээр бий болгосон.

### 4. Сүлжмэлийн үйлдвэртэй холбоотой:

- Сүлжмэлийн үйлдвэрийн 1, 2-р албыг нэгтгэн Сүлжих алба, Оёх алба, Гүйцэтгэх алба болгон төрөлжүүлэн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн.

### 5. Нэхмэлийн үйлдвэртэй холбоотой:

- Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах албаны зохион байгуулалтыг өөрчлөн машинт болон гар дамжлагаар ялгаж салгасан.



## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



**ХАЙЛААР ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ**

2 сард ӨМӨЗОрны Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотод шинэ франчайз дэлгүүрийн нээлтийг хийсэн.




**ГАДААД ХАРИЛЦАГЧДЫН ЗАХИАЛГЫГ НЭГДСЭН БАЙДЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

3 сард Брюссель болон Берлин хотуудад гадаад харилцагч нарт зориулан 2019 оны Намар/Өвлийн шинэ коллекцийг танилцуулж, захиалгыг нэгдсэн байдлаар авах арга хэмжээг зохион байгуулав. Ингэснээр үйлдвэрлэлийн бүтээмжээ нэмэгдүүлэхэд өндөр үр дүнтэй юм.



**ДЮССЕЛЬДОРФ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ**

3 сард Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дюссельдорф хотод 130 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрийн нээлтийг хийсэн.



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**


4 сарын 17-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд зохион байгууллаа. Хуралд нийт 6,946,873 саналын эрхтэй 210 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 89.05% байв.





## ИСТАМБУЛ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

4 сард Бүгд Найрамдах Турк улсын Истамбул хотод 260 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрийн нээлтийг хийсэн.



## ОНЛАЙН ХУДАЛДААГАА ӨРГӨЖҮҮЛЛЭЭ

2017 онд [www.gobicashmere.com](http://www.gobicashmere.com) гэсэн өөрийн онлайн худалдааны сайтаас гадна ТАОВАО сайт дээр бүтээгдэхүүнээ байршуулан онлайн худалдааг эхлүүлсэн бол онлайн худалдааны сувгаа өргөжүүлэн энэ онд АНУ-ын жижиглэнгийн худалдааны 43.5% эзэлдэг 310 сая идэвхтэй хэрэглэгчтэй [amazon.com](http://amazon.com) сайтаар дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.



## ТАЛАРХЛЫН ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2017 онд үйлдвэрийн дээвэрт гарсан галын аюулыг бид хөдөлмөрч хамт олон болон сайхан сэтгэлт Монгол түмнийхээ дэмээр давж гарч үйлдвэрийнхээ үйл ажиллагааг богино хугацаанд сэргээж чадсан тул жилийн дараа буюу энэ оны 6 сарын 14-нд галын ослын үед халуун сэтгэлийн гараа сунган сэтгэл санаа болон эд материалын тусламж үзүүлсэн төрийн болон хувийн өмчит аж ахуй нэгж байгууллага, хувь хүмүүсийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.



## АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭРИЙН ШАВ ТАВИХ ЁСЛОЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

6 сарын 15-нд Төв аймгийн Сэргэлэн сумын 14.7 га газар шинээр барихаар төлөвлөж буй Анхан шатны цогц үйлдвэрийн шав тавих ёслолыг амжилттай зохион байгуулав.





## ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТ

### АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭР



2017 оноос эхлэн Хятадын шинэ загварын самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, чанарын үл тохирлыг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ онд нэмэлтээр 5 шугам суурилуулсан.

### ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр утасны даацыг сайжруулахаас гадна бүтээгдэхүүнд бөөсрөлт үүсгэхгүй байх зэрэг эерэг үр дүнтэй. Цаашид Muratec шилжүүлэн ороох машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэх машинаар ээрнэ.



### ОЁМОЛЫН ҮЙЛДВЭР



2018 онд ноолууран пиджакны борлуулалтаар дэлхийд тэргүүлэх зорилгын хүрээнд эмэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан ХБНГУ-ын Indupress тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн. Цаашид эрэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан Malka тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн масс үйлдвэрлэлийг эхлүүлнэ.


## СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Сүлжмэлийн үйлдвэрийн оёх дамжлага дээр Италийн Comlett K&S үйлдвэрийн шидээсний машиныг нэвтрүүлж кеттель болон шидээсний машиныг хослуулан хэрэглэж эхэлснээр ажилбарын урт болон хугацааг хэмнэхээс гадна үйлдвэрлэлийн бүтээмжийг 43% өсгөн сард 90,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэсэн зорилгодоо хүрэх боломжтой болно.



Японы SHIMA SEIKI MACH2XS оёдолгүй сүлжих 6 ширхэг машиныг шинээр ашиглалтад оруулсан. Энэхүү машин нь бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжиж гаргахаас гадна цамцны захыг өөрөөсөө сүлжиж гаргах онцлогтой юм.

## ТОЁОТА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СИСТЕМ



Тоёота Үйлдвэрлэлийн Систем (Toyota Production System)–г үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр Японы мэргэжилтэн Хори Жүнжи-г урин Говь ХК-тай танилцуулсан бөгөөд үйлдвэрийн ээлж зохион байгуулалтыг сайжруулах, дамжлага дундын үлдэгдлийг бууруулах, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг илүү боловсронгуй болгох арга барилын талаар туршлага солилцон ажилласан. Цаашид компанийн хэлтэс, нэгж бүр үйл ажиллагаандаа Кайзен системийг нэвтрүүлэн ажилтан бүр бүтээмжээ нэмэгдүүлэх дээр санал санаачилга гарган ажиллахыг зорьж байна.



## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

### ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



3D принттэй бүтээгдэхүүн



Splendor утастай бүтээгдэхүүн



Хатгамалтай бүтээгдэхүүн



Үстэй сүлжмэл бүтээгдэхүүн



Хэлхэр загварын эмэгтэй пиджак



Загвар, суултыг нь сайжруулсан эрэгтэй пиджак



Германы алдарт дизайнер Anna Von Griesheim-тай хамтарсан ОНЦГОЙ ЗАГВАРЫН ПАЛЬТО



Зураач С.Саранцацралт болон Н.Туяа нартай хамтарсан принттей шааль



## ШИНЭ КОЛЛЕКЦИУД

### ҮНДСЭН КОЛЛЕКЦ



ЦАГААН САР 2018



ХАВАР/ЗУН 2018



YAMA ХАВАР/ЗУН 2018




НААДАМ 2018

### НЭМЭЛТ КОЛЛЕКЦ




"САРНЫ ТҮРЛЭГ"  
БАРЛАСАН ШААЛЬ



ПАСТЕЛ ӨНГӨТЭЙ  
ПИДЖАК



GOBI KIDS 2018



DANDELION 2018



## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2018.06.30			2017.06.30 гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт		тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	56,304	55,648	99%	33,946	21,702	64%
Дотоод борлуулалт	сая.төг	35,726	36,486	102%	23,778	12,709	53%
Гадаад борлуулалт	сая.төг	20,578	19,162	93%	10,168	8,994	88%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	35,816	32,780	92%	20,163	12,617	63%
НИЙТ АШИГ	сая.төг	20,488	22,868	112%	13,783	9,086	66%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	13,766	14,787	107%	10,109	4,678	46%
Татварын өмнөх ашиг	сая.төг	6,811	5,697	84%	4,497	1,200	27%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	5,494	4,417	80%	3,395	1,022	30%
Цэвэр ашгийн хувь	хувь	10%	8%	81%	10%	0	-21%
Экспорт	мян.USD	8,399	7,910	94%	4,200	3,710	88%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	49,583	47,567	96%	30,272	17,295	57%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.88	0.85	97%	0.89		
ҮЙЛДВЭРЛЭЛТ							
Сүлжмэл	ширхэг	376,250	345,805	92%	256,859	88,946	35%
Нэхмэл	метр	274,329	293,162	107%	253,976	39,186	15%
Оёмол	ширхэг	35,168	36,555	104%	26,561	9,994	38%
Үүнээс: Пальто	ширхэг	26,545	26,972	102%	23,435	3,537	15%
Ээрмэл	тонн	214,854	197,331	92%	151,606	45,726	30%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ							
Ноолуур	тонн	850	762	90%	584	178	30%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	2,156	2,005	93%	1,695	310	18%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	26,115	27,755	106%	20,027	7,728	39%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	15,800	11,233	71%	6,842	4,391	64%

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Цэвэр ашиг

**4.4**

тэрбум төг

Төлсөн  
татвар**11.5**

тэрбум төг

Хөрөнгө  
оруулалт**11.2**

тэрбум төг

## ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

Дотоод  
борлуулалт**36.5**

тэрбум төг

Дотоод  
зах зээлд  
эзлэх %**73%**Салбар  
дэлгүүр**8**

## ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



Экспорт

**19.2**

тэрбум төг

Гадаад  
зах зээлд  
эзлэх %**61%**

13 орны 34 хотод

Салбар дэлгүүр

**5**

Франчайз дэлгүүр

**53**

## ҮЙЛДВЭРЛЭЛТ



Сүлжмэл

**346**

мян. шир



Нэхмэл

**293**

мян. метр



Оёмол

**37**

мян. шир

## ХҮНИЙ НӨӨЦ

Ажилтнуудын  
тоо**2,005**Эрэгтэй  
**26%**  
Эмэгтэй  
**74%**

Захиргаа

**248**

Борлуулалт

**236**

Үйлдвэр

**1,521**

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 6 сарын 30  
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2017.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,506,609	7,183,762
Дансны ба бусад авлага	12,678,385	11,644,199
Урьдчилгаа төлбөр	8,653,191	2,811,450
Бараа материал	179,830,968	101,271,760
	<u>202,669,153</u>	<u>122,911,171</u>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
Үндсэн хөрөнгө	65,121,114	57,274,775
Хойшлогдсон татварын хөрөнгө	413,258	83,931
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	9,000	459,043
	<u>65,543,373</u>	<u>57,817,749</u>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>268,212,526</u>	<u>180,728,920</u>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Дансны ба бусад өглөг	15,328,135	6,372,509
Орлогын албан татварын өглөг	1,172,740	1,971,410
Богино хугацаат банкны зээл	55,464,998	40,469,033
	<u>71,965,873</u>	<u>48,812,952</u>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Урт хугацаат банкны зээл	91,970,760	30,202,780
	<u>91,970,760</u>	<u>30,202,780</u>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<u>163,936,633</u>	<u>79,015,732</u>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	15,647,697	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(166,791)	(28,274)
Хуримтлагдсан ашиг	88,014,874	85,313,652
	<u>104,275,893</u>	<u>101,713,188</u>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<u>268,212,526</u>	<u>180,728,920</u>



## НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2018 оны 6 сарын 30  
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2017.12.31
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>	55,647,981	124,425,107
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(32,779,582)	(73,880,650)
<b>НИЙТ АШИГ</b>	22,868,399	50,544,457
Санхүүгийн ба бусад орлого	294,037	848,816
Бусад олз ба (гарз)	(2,678,736)	(571,863)
Хүүгийн зардал	(4,000,110)	(6,496,773)
Борлуулалт ба маркетингийн зардал	(6,809,622)	(12,121,296)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,977,237)	(8,761,080)
<b>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ</b>	5,696,731	23,442,261
Орлогын татварын зардал	(1,279,262)	(5,939,277)
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ</b>	4,417,469	17,502,984
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:		
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(138,517)	(28,274)
Бусад иж бүрэн (зарлага)/орлого	(138,517)	(28,274)
<b>НИЙТ ИЖ БҮРЭН ОРЛОГО</b>	4,278,952	17,474,710
<b>НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ</b>	0.55	2.24

## НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 6 сарын 30  
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	ХУВЬЦААТ КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭ НЭМЭГДЭЛ	ВАЛЮТЫН ХӨРВҮҮЛЭЛТИЙН НӨӨЦ	ХУР/АШИГ	НИЙТ
<b>2016.12.31 ҮЛДЭГДЭЛ</b>	780,113	15,647,697	-	69,370,893	85,798,703
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	17,502,984	17,502,984
Бусад иж бүрэн орлого	-	-	(28,274)	-	(28,274)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(28,274)	17,502,984	17,474,710
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,560,225)	(1,560,225)
<b>2017.12.31 ҮЛДЭГДЭЛ</b>	780,113	15,647,697	(28,274)	85,313,652	101,713,188
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	4,417,469	4,417,469
Бусад иж бүрэн орлого	-	-	(138,517)	-	(138,517)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(138,517)	4,417,469	4,278,952
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,716,248)	(1,716,248)
<b>2018.06.30 ҮЛДЭГДЭЛ</b>	780,113	15,647,697	(166,791)	88,014,874	104,275,892



## НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 6 сарын 30  
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2017.12.31
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ</b>	4,417,470	17,502,984
Тохируулгууд:		
Элэгдэл ба хорогдлын зардал	2,803,568	5,633,556
Орлогын татварын зардал	1,279,262	5,939,277
Хүүгийн зардал	4,000,110	6,496,773
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (ашиг)/алдагдал	2,092,333	149,478
Найдваргүй авлагын зардал	-	-
Бараа материалын хасагдуулгын зардал/(нөхөлт)	17,310	(169,909)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз/(олз)	157,874	181,228
Үндсэн хөрөнгө болон бараа материалыг бүртгэлээс хассанаас илүү давсан даатгалын нөхөн олговор	-	(383,784)
	14,767,927	35,349,603
Дансны ба бусад авлагын өсөлт	(1,034,186)	(5,545,377)
Урьдчилгаа төлбөрийн бууралт/(өсөлт)	(5,841,741)	(353,745)
Бараа материалын өсөлт	(78,559,208)	(43,127,472)
Дансны ба бусад өглөгийн өсөлт/(бууралт)	7,214,664	2,235,534
	(63,452,544)	(11,441,457)
Төлсөн орлогын татвар	(2,541,389)	(6,312,721)
Төлсөн хүү	(3,533,037)	(6,183,446)
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(69,526,970)</b>	<b>(23,937,624)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН Ү/А-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	11,000	245,456
Даатгалын нөхөн олговроос орж ирсэн мөнгө	-	4,400,000
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(11,233,398)	(14,530,295)
Худалдан авсан бусад эргэлтийн бус хөрөнгө	-	(38,503)
Холбоотой талд өгсөн санхүүжилт	-	(11,430,480)
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	-	25,430,480
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН Ү/А-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(11,222,398)</b>	<b>4,076,658</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Авсан зээл	149,958,970	100,162,894
Төлсөн зээл	(74,410,012)	(74,023,755)
Төлсөн ногдол ашиг	(458,909)	(1,681,761)
Холбоотой талуудаас авсан санхүүжилт	-	17,046,070
Холбоотой талуудаас авсан санхүүжилтэнд төлсөн дүн	-	(17,046,070)
<b>САНХҮҮГИЙН Ү/А-НЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>75,090,049</b>	<b>24,457,378</b>
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	(17,834)	(26,920)
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН (БУУРАЛТ)/ӨСӨЛТ</b>	<b>(5,677,153)</b>	<b>4,569,492</b>
<b>ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>7,183,762</b>	<b>2,614,270</b>
<b>ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,506,609</b>	<b>7,183,762</b>

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн болно.

(мян. төг)

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2018.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	-
Холбоотой талаас авсан санхүүжилт	-
Холбоотой талтай хийсэн борлуулалт	4,046,808
Холбоотой талаас авсан худалдан авалт	722,562
Хүүгийн орлого	-
Хүүгийн зардал	-
Түрээсийн орлого	56,516
Түрээсийн зардал	83,373

## САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

БАНКНЫ НЭР	2018.06.30	2017.12.31	ЭЗЛЭХ ХУВЬ
Голомт Банк	24,628,200	5,928,952	17%
Худалдаа Хөгжлийн Банк	9,700,000	9,760,000	7%
Монгол Улсын Хөгжлийн Банк	67,702,560	19,417,04	46%
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	24,628,200	14,562,780	17%
Хас Банк	14,776,798	14,562,780	10%
Азийн Хөгжлийн Банк	6,000,000	6,000,000	4%
САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	147,435,758	70,231,552	100%

## КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ


(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2018.06.30	2017.06.30
ТУЗ-ийн цалин урамшуулал	57,080	45,100
Удирдлагын цалин урамшуулал	345,068	212,122
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	21,259	16,766
НИЙТ	423,407	273,988



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

### ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



### ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30		2017.12.31	2017.06.30	
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО (шир)	7,801,125		7,801,125	7,801,125	
Төрөл	энгийн хувьцаа		энгийн хувьцаа	энгийн хувьцаа	
ХУВЬЦААНЫ ҮНЭ (төг)	Өсөлт, бууралт /%/				
		2017.12.31-нээс	2017.06.30-наас		
Хаалтын үнэ	24,020	3.3% ↑	84.1% ↑	23,260	13,050
Хамгийн их үнэ	27,640	21.4% ↓	86.6% ↑	35,180	14,810
Хамгийн бага үнэ	20,520	113.7% ↑	113.7% ↑	9,600	9,600
Дундаж үнэ	23,338	41.1% ↑	87.3% ↑	16,535	12,462
АРИЛЖААЛАГДСАН ТОО (шир)	64,237	54.1% ↓	28.1% ↑	140,047	50,161
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН (мян. төг)	1,506,829	42.0% ↓	139.3% ↑	2,598,886	629,740
КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (мян. төг)	187,383,022	3.3% ↑	84.1% ↑	181,454,167	101,804,681

## НОГДОЛ АШИГ

### НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (мян. төг)	Ногдол ашиг тараалт
1996	61	475,869	Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	154	1,199,813	
1998	150	1,170,169	
1999	166	1,294,987	
2000	100	780,113	
2001	20	157,271	
2005	60	468,068	
2006	60	468,068	
2010	100	780,113	ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан.
2011	100	780,113	
2012	125	975,141	
2013	130	1,014,146	
2014	140	1,092,158	
2015	140	1,092,158	
2016	200	1,560,225	
2017	220	1,716,247	2018 оны 4 сарын 24-ний өдрөөс тарааж эхэлсэн.

### 2017 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2 сарын 2-ны өдрийн хурлын №4 тогтоолоор 2017 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 220 төгрөг буюу нийт 1,716,247,500 төгрөгийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ 10% өссөн үзүүлэлттэй байв.


2017 оны ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2018 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.




2018 онд компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- Ногдол ашгийн журмыг боловсруулан батлах
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг боловсруулан батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулан батлах
- Мэдээллийн үйл ажиллагааны үйл ажиллагааны журмыг боловсруулан батлах
- Эрх бүхий албан тушаалтнуудын бодлогыг боловсруулан батлах
- ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийх зэрэг ажлуудыг хийсэн.

Цаашид энэ ондоо дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

- Компанийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлах
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг боловсруулан батлах
- Оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах журмыг боловсруулан батлах
- Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийх

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



### ХУВЬЦААНЫ 5%-С ДЭЭШ БАГЦЫГ ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (мян. шир)	Эзэмшлийн хувь
ХИДЕ ИНТЕР ХХК	2,652.4	34.0%
ЭФ-СИ-АЙ ХХК	2,230.0	28.6%
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	1,688.1	21.6%

### НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

7,801,125

### НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

16,238

/2018.06.30-ны байдлаар/

ХИДЕ ИНТЕР ХХК, ЭФ-СИ-АЙ ХХК нь хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь "Таван Богд Групп"-ийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

Өдгөө Өнөөдөр Таван Богд групп нь 15 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, 4 бизнес нэгж, нийт 11,000 гаруй ажиллагсадтай болтлоо өргөжин тэлсэн Монголын бизнесийн салбарын манлайлагч юм.





## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

### ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг 2018 оны 4 сарын 17-ны өдөр 6,946,873 саналын эрхтэй 210 хувьцаа эзэмшигч оролцож, 89.05 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.88%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг 99.85%-ийн саналаар батлав.
3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг батлахад кумулятив аргаар санал хураалт явуулан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр М.Баяр, Д.Гэрэлмаа, Б.Нандин-Эрдэнэ, Такэши Камбэ, З.Шагдарсүрэн нарыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Баатарсайхан, Хидэо Савада, Д.Хулан, Ж.Оюунчимэг нарыг тус тус 3 жилийн хугацаатайгаар сонгох шийдвэр гаргав.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг 99.84%-ийн саналаар батлав.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

#### *Эрсдэл, аудитын хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн үр чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### *Нэр дэвшүүлэх хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

#### *Цалин, урамшууллын хороо*

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

2018 онд Төлөөлөн удирдах зөвлөл 6 удаа, Эрсдэл, аудитын хороо 3 удаа, Нэр дэвшүүлэх хороо 1 удаа, Цалин урамшууллын хороо 1 удаа тус тус хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд нийт 44 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, 25 тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### ХАРААТ БУС ГИШҮҮД

---



**Дамбын  
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга  
Хараат бус гишүүн

/Цалин урамшууллын  
хорооны дарга, Нэр  
дэвшүүлэх хорооны  
гишүүн/

**СЭЗДС, Бизнес  
удирдлагын  
тэнхимийн  
профессор**

---



**Мягмарын  
БАЯР**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Нэр дэвшүүлэх  
хорооны дарга/

**ШУТИС-ийн ҮТС-  
ийн Нэхмэл  
судлалын  
салбарын дэд  
профессор**



**Банзрагчийн  
НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны дарга/

**СЭЗДС, Бизнесийн  
Удирдлагын  
тэнхимийн ахлах  
багш**

---



**Такэши  
КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Цалин урамшууллын  
хорооны гишүүн/

**Asahi Life Insurance  
Менежер**



**Зуунайн  
ШАГДАРСҮРЭН**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн/

**Өмгөөлөгч, Хуулийн  
зөвлөх**

---

## ЕРДИЙН ГИШҮҮД

---



**Цагаачийн  
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

/Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн/

**Таван Богд  
Группийн  
Ерөнхийлөгч,  
Говь ХК-ийн  
Гүйцэтгэх захирал**



**Дашдаваагийн  
ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

/Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн/

**Таван Богд Группийн  
Тэргүүн дэд  
ерөнхийлөгч**



**Хидэо  
САВАДА**

ТУЗ-ийн ердийн  
гишүүн

**Н.И.С компанийн  
Ерөнхийлөгч**



**Жавзандолгорын  
ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн

/Цалин урамшууллын  
хорооны гишүүн/

**Таван Богд Групп,  
Маркетингийн  
хэлтсийн дарга**



## КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

ОВОГ НЭР АЛБАН ТУШААЛ	МЭРГЭЖИЛ АЖЛЫН ТУРШЛАГА
 <p data-bbox="527 506 769 575"><b>Цагаачийн БААТАРСАЙХАН</b></p> <p data-bbox="581 617 716 686">Гүйцэтгэх захирал</p>	<p data-bbox="797 386 1224 417"><b>ЭЛЕКТРОНИКИЙН ИНЖЕНЕР</b></p> <p data-bbox="797 447 1453 625">Алтай ХХК-д Орлогч захирал, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ ХК-иудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан.</p> <p data-bbox="797 667 1453 808">Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн, 2008 оны 8 сараас Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.</p>
 <p data-bbox="542 961 756 1031"><b>Нямжавын СҮРЭНРАГЧАА</b></p> <p data-bbox="545 1073 753 1178">Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал</p>	<p data-bbox="797 884 1029 915"><b>ЭДИЙН ЗАСАГЧ</b></p> <p data-bbox="797 966 1453 1068">Таван Богд Трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежерээр ажиллаж байсан.</p> <p data-bbox="797 1115 1453 1255">2015 оны 4 сараас Говь ХК-ийн Бизнес удирдлагын газрын захирлаар, мөн оны 11 сараас Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>
 <p data-bbox="558 1423 740 1493"><b>Лувсангийн АРИУН</b></p> <p data-bbox="532 1535 766 1640">Гадаад худалдаа хариуцсан дэд захирал</p> <p data-bbox="607 1675 691 1707">/АЗИ/</p>	<p data-bbox="797 1346 1198 1377"><b>МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР</b></p> <p data-bbox="797 1423 1453 1564">KVN Co.Ltd-д Маркетингийн менежер, KVN Co.Ltd-ийн Хонг Конг дахь салбарын Маркетингийн ахлах менежерээр ажиллаж байсан.</p> <p data-bbox="797 1606 1453 1822">2015 оны 7 сараас Говь ХК-ийн Менежмент удирдлагын хэлтэст Бодлого журам хариуцсан менежер, 2015 оны 11 сараас Борлуулалт хариуцсан дэд захирал, 2017 оны 1 сараас Гадаад борлуулалт хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>





### Ганболдын СЭЛЭНГЭ

Санхүү бүртгэл,  
удирдлагын  
газрын захирал

### САНХҮҮ, БИЗНЕСИЙН УДИРДЛАГА

Гермес Тэсүн ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, Хаан Палас ХХК-д Ахлах нягтлан бодогч, Таван Богд Групп-д Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.

2013 оноос одоог хүртэл Говь ХК-д Санхүү бүртгэл, удирдлагын газрын захирлаар ажиллаж байна.



### Батсуурийн БОЛОРМАА

Бүтээгдэхүүн  
хөгжүүлэлтийн  
газрын захирал

### ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭГЧ

Дархан Минж ХХК-д Дизайнерээр ажиллаж байсан.

2007 оноос Говь ХК-д Чанар шалгагч, 2008 оноос Дизайнер, Загвар зохион бүтээгч, 2016 оноос Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирлаар ажиллаж байна.



### Чулуунбатын СОЛОНГО

Захиргаа, хүний  
нөөцийн газрын  
захирал

### АРХИТЕКТОР

Алтандорнод Монгол ХХК-д Гадаад харилцааны менежер, Боловсон хүчин, Таван Богд Групп-д Гадаад худалдааны менежер, Борлуулалт хариуцсан ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.

2014 оноос Говь ХК-д Захиргаа, хүний нөөцийн газрын захирлаар ажиллаж байна.





**Цогтбаярын  
ЦАСЧИХЭР**

Хуулийн зөвлөх

### ЭРХ ЗҮЙЧ

Хэнтий аймгийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Жаст Ойл ХХК-д Хуулийн зөвлөх, Эм Си Эс ХХК-д Хуульчаар тус тус ажиллаж байсан.

2014 оноос Говь ХК-д Хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.



**Мөнхбатын  
СЭЛЭНГЭ**

ТУЗ-ийн нарийн  
бичгийн дарга

### НЯГТЛАН БОДОГЧ

Нью Хакуба ХХК-д Нягтлан бодогч, Бүрд Петролиум ХХК-д Нягтлан бодогч, Таван Богд Трейд ХХК-д Төслийн туслах менежер, Менежмент удирдлага хариуцсан менежер, Захирлын ажлын албаны менежерээр ажиллаж байсан.

2017 оноос Говь ХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

### ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	122,473ш (1.6%)	ЭФ-СИ-АЙ ХХК 28.6% ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 21.5%
Ц.БААТАРСАЙХАН	500ш (0.0%)	
НИЙТ		51.7%



## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Говь ХК нь тогтвортой хөгжлийг дэмжих ажлын хүрээнд олон улсын төрийн байгууллага Sustainable Fibre Alliance (SFA) буюу Тогтвортой ноос ноолуурын эвслийн гишүүнээр 2017 онд элссэн. Улмаар Тогтвортой ноос ноолуурын эвслийн “Бэлчээрийн зохистой ашиглалт болон малын арчилгаа, маллагааны мөрдөх заалт”-ыг хэрэгжүүлсэн малчид хоршооллын тогтвортой байдлын үзэл баримтлалд нийцсэн ноолуур нийлүүлэх чадамжийг бий болгох тал дээр хамтран ажиллаж байна.

2018 онд Тогтвортой ноолуурын бодлогыг баримталж дараах ажлыг эхлүүлээд байна.



Хоршоодын төлөөлөлд үйлдвэр танилцуулав.



Залаа жинстийн торгон сүрэг хоршооны 2 өрх 29 малчинд хөндлөнгийн үнэлгээ хийв.



Дэлгэрэхийн улаан ямааны хоршоонд сургалт зохион байгуулан 4 өрх 37 малчинд хөндлөнгийн үнэлгээ хийв.

**SFA БУЮУ ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛТЭЙ ХАМТРАН “МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙН БРЭНД” ТӨСЛИЙГ САНААЧЛАН ЭХЛҮҮЛЭВ.**

Дорноговь аймгийн Дэлгэрэхийн улаан ямааны хоршоо, Баянхонгор аймгийн Залаа жинстийн торгон сүрэг хоршоонд Мал маллагаа болон Бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор энэхүү төслийг эхлүүлсэн.

Тус төслийн хүрээнд Сургагч багшийн сургалтыг зохион байгуулан Хоршоодын төлөөлөлд төслийн талаар танилцуулж, мал арчилгаа, бэлчээр ашиглалтын талаар сургалт явуулж, тэднийг хоршооны гишүүддээ сургалт явуулахад нь туслах зааварчилгаа өгөв.

Мөн Говь ХК-ийн үйлдвэрээр танилцах аялалыг зохион байгуулж, сургалтын төгсгөлд оролцогчдын мэдлэг ойлголтыг 8 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд үр дүнд нь энэхүү сургалтанд хамрагдсан малчдын байгууллагын төлөөлөл бэлчээрийг зохистой ашиглах ба малын арчилгаа маллагаа ноолуур бэлтгэхэд олон улсын жишиг стандартыг мөрдөх шаардлага, үндэслэл, ашиг тусыг ойлгож цаашид SFA болон Говь ХК тай хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй болсон.

Цаашид хоршоодууд мал хэрхэн арчилж байгаа, бэлчээрээ мөн хэрхэн ашиглаж байгаа талаар хөндлөнгийн үнэлгээг хийж, дүгнэхээс гадна сургалт болон хөндлөнгийн үнэлгээгээр дамжуулан малчдад шийдэж зохицуулах шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхой болгож, шийдвэрлэн, заавар зөвлөмжийг нарийвчлан гарган 2020 оны 6 сар хүртэл төслийг хэрэгжүүлэн ажиллана.



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

Говь ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа шударгаар явуулж, нийгмийн хариуцлагын өндөр жишиг баримталдаг. Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайхан чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлэн нийгмийн асуудалд нь анхаарч, сурч боловсрох нөхцөлөөр ханган ажилладаг.

### 2018 ОНД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД НИЙГЭМ РҮҮ БОЛОН АЖИЛТНУУД РУУ ЧИГЛЭН ХИЙГДСЭН АЖЛУУД



#### КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭВ

Говь ХК-ийн нийгмийн хариуцлагын бодлогыг шинэчлэн боловсруулж, борлуулагдсан ноолууран пальто болон пиджак бүрээс 1,000 төгрөгийг хуримтлуулан нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд зориулахаар боллоо.



#### АЖИЛТНУУДАА ХӨГЖҮҮЛЭН, СУРГАЛТУУДАД ХАМРУУЛАВ

Компанийн үнэ цэнэтэй баялаг болсон ажилтнуудынхаа өсч хөгжих, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 2018 оны эхний хагас жилд Итали, Япон, Унгар, Герман гэсэн улсуудад 22 ажилтныг урт болон богино хугацааны 6 төрлийн сургалтад хамруулан ажилтнуудынхаа хувь хүний өсөлт болон карьер хөгжилд нь үнэтэй хувь нэмэр оруулав.



#### 276 АЖЛЫН БАЙРЫГ ШИНЭЭР БИЙ БОЛГОВ

Үйлдвэрлэлийн хүчин чадлаа өсгөн 276 хүнийг ажлын байраар хангаж, нийт 2,005 ажилтантай болов. Түүнчлэн алслагдмал дүүрэг, захын хорооллын ажилгүй эмэгтэйчүүдийг цалинтай дадлагажуулан ажиллуулах болон амьдрах байраар хангаж байна.



## ИРЭЭДҮЙН БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭН ХӨГЖҮҮЛЭВ

Боловсролын салбартай хамтын ажиллагааны хүрээнд оюутнуудын цалинтай болон цалингүй дадлагыг үйлдвэрийн байрандаа хийлгэх нөхцөлөөр ханган, мэргэжлийн сургалтын төв, коллеж, коосэн, их сургуулиудтай хамтран ажиллаж байна. 1-р хагас жилд 103 оюутныг үйлдвэр дээрээ дадлагажуулж, 11 оюутныг цалинтай дадлага хийлгэн ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэн хөгжүүлэв.

## УЛСЫН АВАРГА СҮЛЖМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЁДОЛЧИН ШАЛГАРУУЛАХ 2-Р УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын нэр хүндийг өсгөх, салбарын ажил олгогч байгууллагуудын нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, сүлжмэл бүтээгдэхүүний оёдолчны чиглэлээр суралцах суралцагчдын тоог нэмэгдүүлэх, олон нийтэд таниулах, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, урам зориг өгөх зорилгоор Сүлжмэл бүтээгдэхүүний улсын аварга Оёдолчин шалгаруулах II уралдааныг ивээн тэтгэж, Монголын Ноос Ноолуурын Холбоо болон Монгол Солонгос Политехникийн Коллежтэй хамтран үйлдвэр дээрээ амжилттай зохион байгуулав.



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЦЭЦЭРЛЭГ ЯСЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолборын хүүхдүүдэд Олон Улсын Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан бэлэг тараав.

Цаашид тус цэцэрлэг яслийн анги танхимын тохижилт, засварын ажлууд болон шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин ажиллана.



“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081

Имэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn)